



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

**Гүйцэтгэх захирлыг жинхлэн томилох
тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэг, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирлаар Баатарын Эрдэнэбулганыг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс жинхлэн томилсугай.

2. Гүйцэтгэх захирал Б.Эрдэнэбулгантай холбогдох журмын дагуу онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Ц.Шинэхүү/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ШИНЭХҮҮ